



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/224

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, 25.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.12-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын цахим /онлайн/ сургалтыг 2016 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газрын соёмбо танхимд зохион байгуулсугай.

2. Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын цахим сургалтын удирдамжийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цахим сургалт явуулах хичээлийн байр, танхимыг бэлтгэж, шаардлагатай техник хэрэгслээр хангаж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар хэлтсийн дарга, Гамшгийн шуурхай удирдлагын газар (онцгой байдлын хурандаа Б.Ууганбаяр)-т даалгасугай.


4. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын цахим сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион явуулж дүнг танилцуулахыг Гал түймэртэй тэмцэх газар (онцгой байдлын хурандаа С.Залуухүү)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА БӨГӨӨД ШТАБЫН ДАРГА,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА П.БАТТОГТОХ



007717

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 14/024
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ТӨВ ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИЙН САЛААНЫ
ЗАХИРАГЧ НАРЫН ЦАХИМ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг: Сургалтын зорилго

Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын албаны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, гал түймэр унтраах аврах ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, гурван шатны сургалтын гүйцэтгэл, чанар үр дүнг сайжруулах, объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах бие бүрэлдэхүүн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахад чиглэгдэнэ.

Хоёр: Сургалт явуулах хугацаа, газар

Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын сургалтад 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрууд 08:30 цагаас 13:10 цагт, Орхон, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрууд 14:00 цагаас 18:10 цагт, 09 дүгээр сарын 29-ний өдөр Баянхонгор, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Төв аймгийн Онцгой байдлын газрууд 08:30 цагаас 13:10 цагт, Ховд, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий Завхан, Архангай аймгийн Онцгой байдлын газрууд 14:00 цагаас 18:10 цагт тус тус цахимаар, нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нар 14:00-18:10 цагт Онцгой байдлын ерөнхий газрын хурлын танхимд сургалтанд хамрагдана.

Гурав: Сургалтын үеийн зохион байгуулалтын талаар

Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын хууль эрх зүй, дүрэм журам, тушаал, шийдвэрийн талаарх онолын мэдлэгийг дээшлүүлж, салааны захирагчийн хөтлөх баримт бичиг боловсруулах чадавхийг сайжруулах.

Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, аврах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулж явуулах.

Хорт хий утаанаас хамгаалах баг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах.

Гал түймэр унтраах аврах ангид гурван шатны сургалтыг зохион байгуулах, гал түймэр унтраах тооцоо бодох.

Гал түймэр унтраах аврах ангийн бэлтгэл, бэлэн байдал, томилгоот харуул ээлжийн бие бүрэлдэхүүн харуул ээлж халалцах, автомашин тоног төхөөрөмж хүлээн авах. /дүрс бичлэг үзүүлэх/

Галын түймрийн голомтод гал унтраах тархалт, тактикийн сургууль болон хорт хий утаанаас хамгаалах багны 1, 2, 3 дугаар шалгалт. /дүрс бичлэг үзүүлэх/

Дөрөв: Сургалтыг зохион байгуулалт

Сургалт зохион байгуулагдах хугацаанд сургалт явагдах өрөө тасалгаанаас гарахгүй, сахилга, дэг журам, зохион байгуулалтыг хариуцах албан хаагчийг Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нар томилсон байна.

Томилогдсон албан хаагч ирцийг бүртгэж, сургалтад ирээгүй алба хаагчдын шалтгааныг баримтжуулсан байна.

Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нар хээрийн хувцастай сургалтын бэлтгэлийг /дэвтэр, үзэг, шугам, харандаа гэх мэт/ бүрэн хангах.

Сургалтыг хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан албан хаагчдад Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын сахилгын дүрэмд заасны дагуу арга хэмжээ тооцно.

Дүрс бичлэгээр хүргүүлэх сэдвүүд, тооцооны аргачлалыг төв, орон нутгийн Онцгой байдлын газарт урьдчилан хүргүүлсэн байна.

Зургаа: Дүгнэлт

Сургалтын ирц, чанар, үр дүнгийн талаар Онцгой байдлын ерөнхий газрын даргад илтгэх хуудсаар танилцуулж ажиллах.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 14 дугаар тушаалын хэргэдугаар хавсралт

ТӨВ ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАЛ ТҮЙМӨР
УНТРААХ АВРАХ АНГИЙН САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН
ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Оролцох бүрэлдэхүүн: Онцгой байлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар, Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нар.

Зохион байгуулагч: Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар, төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нар.

Хугацаа: 2016 оны 09 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд

Хэрэглэгдэхүүн: Компьютер, проектор, дэлгэц, самбар, самбарын үзэг,

Арга зүй: Онолын хичээл, ярих, асуудал дэвшүүлж тайлбарлах зэрэг сургалтын аргууд.

д/д	Арга хэмжээ, хичээлийн сэдэв	Хугацаа	Хариуцах албан тушаалтан, хичээл заах багш
2016 оны 09 дүгээр сарын 28-29 –ний өдөр			
1	Бүртгэл	08:30-08:50	ГТТГ-ын Гал унтраах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын хошууч Г.Галбадрах
2	Сургалтын зохион байгуулалтын талаар /танилцуулга/	08:50-09:00	ГТТГ-ын Гал унтраах чиглэлийн ахлах мэргэжилтэн, онцгой байдлын дэд хурандаа Ц.Нямбаяр
3	Гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч нарын хууль эрх зүй, дүрэм журам, тушаал, шийдвэрийн талаарх онолын мэдлэгийг дээшлүүлж, салааны захирагчийн хөтлөх баримт бичиг боловсруулах чадавхийг сайжруулах.	09:00-10:00	ГТТГ-ын Гал унтраах чиглэлийн ахлах мэргэжилтэн, онцгой байдлын дэд хурандаа Ц.Нямбаяр, ГТТГ-ын Гал унтраах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын хошууч Г.Галбадрах
4	Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, аврах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулж явуулах.	10:00-10:30	ГТТГ-ын Ой, хээрийн түймэртэй тэмцэх асуудал хариуцсан мэргэжилтэн, онцгой байдлын ахмад С.Галтзул
5	Салааны захирагчийн хөтлөх баримт бичиг боловсруулах.	10:30-11:00	ГТТГ-ын Гал унтраах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын хошууч Г.Галбадрах,
6	Хорт хий утаанаас хамгаалах баг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах.	11:00-11:30	ГТТГ-ын Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, онцгой байдлын хошууч Б.Мөнхсайхан
7	Гал түймэр унтраах аврах ангид гурван шатны сургалтыг зохион байгуулах, гал түймэр унтраах тооцоо бодох.	11:30-12:00	ГТТГ-ын Гал унтраах чиглэлийн ахлах мэргэжилтэн, онцгой байдлын дэд хурандаа Ц.Нямбаяр, ГТТГ-ын Гал унтраах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, онцгой байдлын хошууч Г.Галбадрах

8	Гал түймэр унтраах аврах ангийн бэлтгэл, бэлэн байдал, томилгоот харуул ээлжийн бие бүрэлдэхүүн харуул ээлж халалцах, автомашин тоног төхөөрөмж хүлээн авах. /дүрс бичлэг үзүүлэх/	12:00-12:30	
9	Гал түймрийн голомтод гал унтраах тархалт, тактикийн сургууль болон хорт хий утаанаас хамгаалах багны 1, 2, 3 дугаар шалгалт. /дүрс бичлэг үзүүлэх/	12:30-13:00	
10	ГТТГ-ын даргын үүрэг	13:00-13:10	Гал түймэртэй тэмцэх газрын дарга, онцгой байдлын хурандаа С.Залуухүү

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР